



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 487

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Увс -А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 77,187,794.00 (далан долоон сая нэг зуун наян долоон мянга долоон зуун ерэн дөрөв) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 15,437,558.80 (арван таван сая дөрвөн зуун гучин долоон мянга таван зуун тавин найман төгрөг наян мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Завхан-А33А" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Наранбат, "Увс-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Төмөрчөдөр, "Завхан-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХӨЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002242
22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

'УВС-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ, АШИГЛАХ
ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ "ЗАВХАН-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашигдах жил
1	Автогрейдер XUZHOU XUNG GR-135; 89-53 УБ; арлын дугаар: G-13500319030	2009	1	71,177,500.00	71,177,500.00	14,235,500.00	3
	Starex Hyundai 93-01 УВХ: арлын дугаар: kmhwp81jp5u65110	2019	1	6,010,294.00	6,010,294.00	1,202,058.80	3
Нийт дүн			2	77,187,794.00	77,187,794.00 (далан долоон сая нэг зуун наян долоон мянга долоон зуун ерэн дөрөв)	15,437,558.80 (арван таван сая дөрвөн зуун гучин долоон мянга таван зуун тавин найман төгрөг наян мөнгө)	